



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 6 сарын 15 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Боловсролын тухай” хуулийн 20 дугаар зүйл, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16.2.4, дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, хүүхэд залуучууд, эрүүл ахуйн улсын байцаагчдын дүгнэлт, 2007 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлын шийдвэрээр Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах “Бөөрөлзгөнө” цэцэрлэгийг Б.Дарьсүран, В.Пүрэвжаргал, “Жаргалан” цэцэрлэгийг Д.Мөнхжаргал, “Цуурай” цэцэрлэгийг Д.Тунгалаг, “Улаан малгайт” цэцэрлэгийг Н.Галтхүү, “Хонгор нархан” цэцэрлэгийг Ц.Сарангэрэл, “Басархан” цэцэрлэгийг Ж.Наран, “Номт” цэцэрлэгийг Г.Уянга нарт үүсгэн байгуулахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдуулан цэцэрлэгийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн явуулах, багшлах боловсон хүчний чадавхийг сайжруулан ажиллахыг Үүсгэн байгуулагчдад үүрэг болгосугай.

Гурав. Дээрхи цэцэрлэгүүдийг хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгон, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс /До.Энхбаяр/, Нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар /Дэ.Энхбаяр/, дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГ ӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР